



“ЭРДЭНЭТ УЙЛДВЭР”  
ТӨРИЙН ӨМЧИТ УЙЛДВЭРИЙН ГАЗАР

Нийрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027  
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,  
Цахим шуудан: info@erdenetmc.mn,  
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024. 04. 17 № 07-112-12/4843  
танай -ны № -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧДОД

Хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Азотын станцын сэлбэг +” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/202401021133 дугаартай тендерт оролцохыг сонирхогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим (tender.gov.mn) системээр дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН  
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407018247

## ТОДРУУЛГА

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Азотын станцын сэлбэг+” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/202401021133 дугаартай тендерт тодруулга гарсан байна. ҮҮнд:

### Тодруулга №1

- Нийт төсөвт өртөг цахим систем дээр 1,380,000,000 гэж байгаа боловч **ӨГӨГДЛИЙН ХҮЧНЭГТ-д 1,307,184,631.5 төгрөг гэж заасан байна. Аль нь зөв дүн бэ?**

### ХАРИУЛТ №1

Тус тендерийн төсөвт өртөг 1,380,000,000 төгрөг байсан боловч захиалагч тодорхой тооны химийн бодисыг нь хасаж 1,307,184,631.5 төгрөгийн төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх тендер шалгаруулалтын баримт бичиг баталсан. Ийм тус тендерийн төсөвт өртөг нь 1,307,184,631.5 төгрөг байна.

### Тодруулга №2

- Тендерт нийлүүлэгдэх аль ч сэлбэг нь химийн бус бүтээгдэхүүнүүд байтал яагаад ТШЗ 18.2 дээр "Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй. /олон улсын нэрийл: Nitrogen gaz, химийн томъёо: NO, GAS дугаар: 7727-37-9/ хавсралтад тусгагдсан байх" тусгай зөвшөөрлийг шаардсан юм бол?

### ХАРИУЛТ №2

Захиалагчийн шаардсан бараа нь гадаад улсад үйлдвэрлэгддэг бараа бөгөөд азотын станцын сэлбэг материал (Азот нь өнгө, үнэр, амтгүй, өргөн хэрэглэгддэг инерт хий. Химийн тэмдэглэгээ нь N, атомын дугаар нь 7.) тул хил дамжуулан тээвэрлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг шаардсан. Гэвч хил дамжуулан тээвэрлэхэд тухайн тендерт шаардсан тоног төхөөрөмжинд тусгай зөвшөөрөл шаардлагагүй байх тул тендерийн шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.2 дахь заалтын 1 дэх хэсэгт заасан шаардлагыг үнэлгээнд оруулахгүй, хасаж байна.

### Тодруулга №3

- Мөн энэ тендерийн төрөл нь бараа буюу сэлбэг нийлүүлэх тул ТШЗ 18.2 дээр ашиглах, ажил үйлчилгээ хийхэд ашигладаг "Химийн бодис болон төрөл бүрийн хий даралтат сав, даралтат савны тоног төхөөрөмжээ тэдгээрийн сэлбэг эд анги ашиглах, эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл. Стандарт: ISO-9001, MNS6659-2017" тусгай зөвшөөрөл шаардлагатай гэж үзсэн байна. Энэ дээр тодруулга өгч тусална уу.

### ХАРИУЛТ №3

Барааны барьцаат баталгаат хугацааны (Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 4.10 болон ГЕН 4.11 дэх заалт) үед гарсан гэмтэл доголдлыг арилгах үед зайлшгүй нийлүүлэгч оролцох бөгөөд эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Иймд тус заалтын дагуу баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ үү.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

 Б.ЧИНЗОРИГ

 Ч.ОТГОНБААТАР